



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А/339

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Засгийн газрын 2023 оны 203 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3, 2.1.4, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас зохион байгуулагдаж буй “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын онцлох ажлуудын хэрэгжилтийн явцын талаарх зөвлөлдөх уулзалт оролцох бүх шатны Засаг дарга болон сумын Засаг даргын Тамгын газрын дарга нарын замын зардалд 14,400,000 (Арван дөрвөн сая дөрвөн зуун мянган) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 14,400,000 (Арван дөрвөн сая дөрвөн зуун мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс, гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга (Х.Цэнд-Аюуш)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ